



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 7/22

Ховд

Х.Баасанхүүд чөлөө олгох тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь заалт, Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны А/131 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.3-ын "а" дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтэн Х.Баасанхүү нь эрүүл мэндийн шалтгаанаар чөлөө хүссэн тул 2021 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын 5 хоногийн цалинтай чөлөө олгосугай.

2. Х.Баасанхүүд чөлөөтэй байх хугацааны цалинг бодож олгохыг Санхүү, аж ахуйн тасгийн ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэрт/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ЭНХБОЛД